

**ГОЛ, МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ, УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН  
ХАМГААЛАЛТЫН БҮС, ОЙН САН БҮХИЙ ГАЗАРТ АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ,  
АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, АШИГТ  
МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛҮҮДИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ БАЙГАЛЬ  
ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

**2015 оны 02 дугаар  
сарын 12-ны өдөр**

**Улаанбаатар  
хот**

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн Д.Арвин**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнийг дагаж өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дараах санал, дүгнэлтийг гаргалаа.

Хэлэлцүүлгийн явцад Байнгын хорооноос байгуулагдсан ажлын хэсгээс гарсан зарчмын зөрүүтэй болон найруулгын шинжтэй саналын томьёоллын талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл, С.Оюун нар асуулт асууж, хариулт авсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун нар санал хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар ажлын хэсгээс гарсан саналын томьёоллыг хэлэлцэж, санал нэг бүрээр санал хураалт явууллаа.

Хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай тус Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлт, саналын томьёоллыг Та бүхэнд тараасан болно.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнийг дагаж өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарсан санал,  
дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**С.БАТБОЛД**

2015.02.12

**ГОЛ, МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ, УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН  
ХАМГААЛАЛТЫН БҮС, ОЙН САН БҮХИЙ ГАЗАРТ АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ,  
АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ  
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Нэг.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн  
санал:**

1.Төслийн 2 дугаар зүйл буюу хуулийн 2 дугаар зүйлийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Хууль батлагдахаас өмнө ойн сан бүхий газарт олгогдсон ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь Ойн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, 29 дүгээр зүйл, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг болон 42 дугаар зүйлийн 42.1.5 дахь заалтад заасныг хэрэгжүүлнэ. Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг Усны тухай хуулийн 22.3-д заасны дагуу усны сан бүхий газрын эргээс 200 метрээр тогтоох. Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс, ойн сан бүхий газартай давхацсан тохиолдолд Усны тухай хууль, Ойн тухай хуулийн дагуу шийдвэрлэх.”

**Санал гаргасан: Д.Арвин, О.Баасанхүү, А.Бакей, Д.Батцогт, Ж.Батсуурь, Б.Бат-Эрдэнэ, З.Баянсэлэнгэ, Ц.Дашдорж, М.Зоригт, С.Одонтуяа, Я.Содбаатар, Л.Эрдэнэчимэг.**

“2.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тухайн аймгийн Засаг дарга гэрээ хийж, хяналтыг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

**Санал гаргасан: Д.Арвин, О.Баасанхүү, А.Бакей, Д.Батцогт, Ж.Батсуурь, Б.Бат-Эрдэнэ, З.Баянсэлэнгэ, Ц.Дашдорж, М.Зоригт, С.Одонтуяа, Я.Содбаатар, Л.Эрдэнэчимэг.**

“2.2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолт явуулсан талбайд нөхөн сэргээлт хийгээгүй тохиолдолд нөхөн сэргээлт хийхэд гаргах зардлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч бүрийн ашиглалт явуулсан хугацаанд олсон орлоготой нь уялдуулан нөхөж гаргуулна.”

**Санал гаргасан: Д.Арвин, О.Баасанхүү, А.Бакей, Д.Батцогт, Ж.Батсуурь, З.Баянсэлэнгэ, Б.Бат-Эрдэнэ, Ц.Дашдорж, М.Зоригт, С.Одонтуяа, Я.Содбаатар, Л.Эрдэнэчимэг.**

2.Төслийн 1 дүгээр зүйл буюу хуулинд нэмэлтээр орж байгаа 3 дугаар зүйлийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл.**Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгогдсон тусгай зөвшөөрлүүдийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам болон гэрээний загварыг Засгийн газар батална. Уг журам, гэрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах зардлыг 100 хувь урьдчилан байршуулах нөхцөл, хяналт тавих төрийн байгууллагын албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тус тус тусгасан байна.”

**Санал гаргасан: Д.Арвин, О.Баасанхүү, А.Бакей, Д.Батцогт, Ж.Батсуурь, Б.Бат-Эрдэнэ, Баянсэлэнгэ, Ц.Дашдорж, М.Зоригт, С.Одонтуяа, Я.Содбаатар, Л.Эрдэнэчимэг.**

3.Төслийн 3 дугаар зүйлийн “энэ хууль батлагдсанаас хойш 6 сарын дотор” гэснийг “энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш 3 сарын дотор” гэж өөрчлөх, хууль дагаж мөрдөх хугацааг ердийн журмаар тогтоох.

**Санал гаргасан: Д.Арвин, О.Баасанхүү, А.Бакей, Д.Батцогт, Ж.Батсуурь, З.Баянсэлэнгэ, Ц.Дашдорж, М.Зоригт, С.Одонтуяа, Л.Эрдэнэчимэг.**

#### **Найруулгын шинжтэй санал:**

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу нэмэлтээр орж байгаа 4 дүгээр зүйлийн “шаардлага хангахгүй” гэснийг “гэрээ байгуулаагүй” гэж өөрчлөх.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “... ашиглалтын” “хуулийн 2, 3 дугаар зүйлд заасан шаардлагыг хүлээн зөвшөөрч” гэснийг тус тус хасах.

3.Хуулийг дагаж мөрдөж эхлэх хугацааг ердийн журмаар тогтоосонтой уялдуулан дагаж өргөн мэдүүлсэн Ашиг малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн дагаж мөрдөж эхлэх хугацааг ердийн журмаар тогтоох.

-oOo-